



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/287

Хэрлэн сум

### Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн зохион байгуулах ажлын хэсгийг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүүхийн эрхийг хамгаалах тухай хуулийн 17.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 23 дугаар хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн 2024 оны төлөвлөгөөний 11 дэх арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийн хүрээнд “Нэгдүгээрт хүүхэд” уриатай нөлөөллийн аян зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга

Аймгийн засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дарга

дарга

Аймгийн засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Гадаад харилцаа, шагнал, ёслолын асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд

Аймгийн засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн нийгмийн хамгааллын бодлого хариуцсан мэргэжилтэн

Аймгийн засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн дарга

Цагдаагийн газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

Соёл урлагийн газрын дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Биеийн тамир спортын газрын дарга

Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын дарга

2.

Онцгой байдлын газрын орлогч дарга

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын Хүүхдийн  
хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн

Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга

2.Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийг орон нутагтаа “Нэгдүгээрт  
хүүхэд” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхийг сумын Засаг дарга, Тосгодын захирагч  
нарт даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын  
Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

